



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 805

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 102,917,000.00 (нэг зуун хоёр сая есөн зуун арван долоон мянга) төгрөгийн балансын үнэ, 38,593,874.97 (гучин найман сая таван зуун ерэн гурван мянга найман зуун далан дөрвөн төгрөг ерэн долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Багануур АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Б.Ичинхорлоо, “Багануур АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Мягмаржаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөлтийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
123007248
37-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн
845 дугаар тогтоолын хавсралт

"ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР" ТӨААТҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
"БАГАНУУР АЗЗА" ТӨХК-Д БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/а шиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ланд Крузер-200, 02-44 УНУ, JTMHX05J004036747	2013/2013	102,917,000.00	38,593,874.97	64,323,125.03
	НИЙТ ДҮН		102,917,000.00 (нэг зуун хоёр сая есөн зуун арван долоон мянган)	38,593,874.97 (гучин найман сая таван зуун ерэн гурван мянга найман зуун далан дөрвөн төгрөг ерэн долоон мөнгө)	64,323,125.03 (жаран дөрвөн сая гурван зуун хорин гурван мянга нэг зуун хорин таван төгрөг гурван мөнгө)